



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар В/265

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 16 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 06 дугаар сарын 4-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,363,421.0 /гурван сая гурван зуун жаран гурван мянга дөрвөн зуун хорин нэгэн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 16 дугаар цэцэрлэг /Д.Оюунчимэг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 557,500.0 /таван зуун тавин долоон мянга таван зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 5 нэр төрлийн 2,805,921.0 /хоёр сая найман зуун таван мянга есөн зуун хорин нэгэн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 16 дугаар цэцэрлэг /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115070900667

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 06 дугаар сарын 08 ны өдрийн
0.125 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 16 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУГ-ын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Будаа агшаагч	7	ø	1	192000	192,000.0	192,000.0	-	Ашиглалтын хугацаа дууссан, ажилладаггүй.	актлах	татах
2	Проектор	7	ø	1	1143994	1,143,994.0	1,143,994.0	-	Ашиглалтын хугацаа дууссан, ажилладаггүй.	актлах	татах
3	Угаалгын машин	13	ø	1	416070	416,070.0	416,070.0	-	Ашиглалтын хугацаа дууссан, ажилладаггүй.	актлах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн						1,752,064.0	1,752,064.0	-			
Тавилга, эд хогшил											
4	Хүүхдийн тоглоом - гал тогооны плитка	11	ш	4	25000	100,000.0	100,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн.	актлах	устгах
5	Хүүхдийн тоглоом - модон вагон	11	ш	4	16000	64,000.0	64,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн.	актлах	устгах
6	Хүүхдийн тоглоом - үг хөгжлийн багц	11	ш	8	8000	64,000.0	64,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн.	актлах	устгах
7	Хүүхдийн тоглоом - тооллогын багц	11	ш	4	48000	192,000.0	192,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн.	актлах	устгах
8	Төгөлдөр хуур	24	ш	1	493857	493,857.0	493,857.00	-	Ашиглалтын хугацаа дууссан, засах боломжгүй.	актлах	татах

9	Компьютерийн ширээ	7	ш	1	137500	137,500.0	137,500.00	-	Ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн.	актлах	устгах
10	Тавиур	11	ш	16	35000	560,000.0	560,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн.	актлах	татах
Тавилга, эд хогшлын дүн						1,611,357.0	1,611,357.0	-			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						3,363,421.0	3,363,421.0	0.00			
Үүнээс Татан төвлөрүүлэх хөрөнгө						2,805,921.0	2,805,921.0	0.0			
Актлах хөрөнгө						557,500.0	557,500.0	0.0			